БАТЛАВ

ББЭХС ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ... БАТТУЛГА

2024 он...сар...өдөр

ХӨДӨЛМӨР ХАМГААЛЛЫН ӨВӨЛ, ЗУН, ГАГНУУРЧНЫ, АЖЛЫН ХУВЦАС, АЖЛЫН БЭЭЛИЙ ХУДАЛДАН АВАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ажлын тоо хэмжээ: Өвлийн хувцас – 14 хос

Зуны хувцас – 133 хос

Тосны хувцас- 30 ширхэг

Шуурхай ажиллагааны ажилчдын ажлын бээлий – 131 хос

Өвлийн ажлын бээлий – 40 хос

Гагнуурчны хувцас / бээлий , комбинзон / - 1 хос

Хантааз /Гадны зочид / -20 ширхэг

1.Ажлын тусгай хувцас

Ажлын тусгай хувцасны дизайн, үйлдвэрлэл дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Ажлын тусгай хувцас нь "Ажлын тусгай хувцас — ерөнхий шаардлага **MNS 13688:2000**", тусгай зориулалтын ажлын хувцас **MNS 6231:2011** Монгол улсын стандартуудтай дүйцэхүйц шаардлагыг хангасан байна.
2. Хувцасны материал нь эрх бүхий байгууллагаар шалгагдаж баталгаажсан байна.
3. Хувцасны бүрдэл хэсгүүд нь хөдөлгөөнд саад болохгүй байх.
4. Хувцасны загвар нь хөдөлмөрийн нөхцөл, биеийн хөдөлгөөний онцлогт тохирсон байх.
5. Хөдөлгөөн болон гадаад орчны хүчин зүйл, сөрөг нөлөөллийг тооцсон хэрэглээний хугацааг урьдаас тооцож баталгаажуулсан байх.
6. Ажлын тусгай хувцсыг үйлдвэрлэснээс хойш 2-оос доошгүй жил ердийн нөхцөлд хадгалсны дараа тэдгээрийг ашиглах боломжтой байх.
7. Хувцасны масс нь түүнийг өмсөж байгаа хүнд ачаалал өгөхгүйгээр хөнгөн байна.

1.1 Ажлын тусгай хувцсанд тавих нэмэлт шаардлага

1. Энгийн болон химийн аргаар цэвэрлэх боломжтой байх.
2. Ус, тос, масло нэвтрүүлэхгүй байх.
3. Төмөр буюу металл гадаргуутай хүрэлцэх үед хувцас нь цахилгаанжихгүй, үрэлтэд гэмтэх, цооролт үсэхгүй байх.
4. Хүний биед харшлахгүй материалаар хийх.

5. Ажлын үед шаардлагатай багаж хийх халаас, өндрөөс унахаас хамгаалах бүс зүүх бололцоотой байх. Дээшээ авирах, суух, бөхийх үед хөдөлгөөнд саад болохооргүй байна.
6. Цахилгаан нумын түлэгдэлт, галын үед хувцасны бүрдэл хэсэг хүний биед наалдахгүй, хүний биетэй шүргэлцэх хэсэг цэвэр даавуугаар хийгдсэн байна.
7. Өвдөг тохой, өгзөгний хэсгээр нэмэлт давхарлагатай байна
8. Харанхуй, гэрэлтүүлэг муутай үед хүний нүдэнд өртөх зорилгоор цээж болон нурууны ар хэсгээр гэрэлтдэг оруулгатай байна.

1.2 Ажлын тусгай хувцасны материалд тавигдах шаардлага

1. Хувцасны материал нь эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй. Жишээ нь хөлстэй наалдах үед харшил өгөхгүй.
2. Тос ус нэвтрүүлэхгүй, хүчилд тэсвэртэй. Хамгаалах чадварыг сайжруулах зорилгоор байглийн ба хиймэл ширхэгт, түүний холио болон төрөл бүрийн боловсруулалт (ус үл нэвтрүүлэх, тос үл нэвчих) хийсэн материалуудыг хэрэглэнэ.
3. Цахилгаанжихгүй, цахилгаан зайлуулагчтай байх.
4. Хэрэглээний дараа хялбар цэвэрлэгддэг байх. Цэвэрлэгээний үед болон нойтон боловсруулалтын үед будаг гарахгүй байх.
5. Галд тэсвэртэй. Цахилгаанжихгүй ажлын байрны онцлогт тохирсон **TC 65/35** гэсэн харьцаатай материалаар хийгдсэн байх.

1.3 Өвлийн хувцасны дотрын материал

2. Дулаалга доторлогооны материалыг -30°C-аас – 40°C хүртэлх температурт өмсөж, хэрэглэх нөхцөлөөр тооцож сонгоно.
3. Өвлийн хувцас даавуу ширээстэй болон салдаг нэхий гэсэн 2 дотортой.
4. Даавуу дотор нь атлас нэхээстэй гөлгөр даавуу байна.
5. Даавуу дотор нь сайн чанарын дотор хувцастай үрэлт үүсэхгүй цахилгаанжихгүй, бөөсрөхгүй .
6. Хүний биеийг хүйтний улиралд хайрахаас сэргийлж цээжний хэсэгт Дархан нэхийтэй дүйцэхүйц салдаг зөөлөн нэхий дотортой байна.
7. Нэхий дотор нь цайвар өнгийн зүүдэл багатай байна.

1.4 Тэмдэглэгээ

1. Ажлын тусгай хувцас бүр компанийн нэрийн товчилсон үсгүүдийг тэмдэглэсэн тэмдэглэгээтэй байна.
2. Хүрэмний зүүн энгэрт лого, ар нуруун дээр компанийн нэрийн товчилсон үсгүүдийг байрлуулна.
3. Тэмдэглэгээ нь нүдэнд харагдахуйц тод бөгөөд ойлгомжтой байх.
4. Цэвэрлэгээний үйл явцад арилахааргүй байх.
5. Тэмдэглэгээ нь боломжийн хэмжээний том, тод ойлгомжтой шифрээр бичигдсэн байна.

6. Компанийн нэрийн товчилсон үсгүүдийг хатгамлын машинаар хатгаж оёно.
7. Хүрэмний зүүн энгэрт байрлах компанийн лого бүхий хатгамлыг халаасны дээр түүнээс 5 мм зайтай оёно.
8. Ар нуруун дээр байрлах компанийн нэрийн хатгамлыг биеийн цээж хэсгийг голлуулан байрлуулна.
9. Зуны хувцасны тэмдэглэгээ нь цээжний саарал оруулга дээр улаан хүрэн өнгөөр бичсэн байна.
10. Өвлийн хувцасны тэмдэглэгээ нь их биеийн улаан хүрэн дээр хар саарал /817/ өнгөөр бичсэн байна. Үсгийн өндөр-**64** мм, Үсэг өргөн-**44** мм, Үсэг хоорондын хэмжээ -**5** мм, Үг хоорондын хэмжээ-**15** мм байна.

1.5 Ашиглалтын хугацаа

1. Ашиглалтын хугацааг дараах хүчин зүйлээс хамааруулан үзнэ. Үүнд: цэвэрлэгээ, өнгө гандалт, хэмжээний өөрчлөлт зэрэг болно.
2. Ажлын тусгай хувцас нийлүүлэгч аж ахуй нэгж, үйлдвэрлэгч нь ашиглалт эдэлгээний явцад хувцасны чанар, үр ашигт орох өөрчлөлт нь заасан хугацаанд стандартын шаардлагад нийцсэн хувцсыг нийлүүлнэ. Ашиглалтын дурдагдсан хугацаанд хувцасны чанарыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.

1.6 Цэвэрлэгээ угаалга

1. Ажлын тусгай хувцсыг энгийн ба химийн аргаар цэвэрлэх боломжтой байна.
2. Ус, тос үл нэвтрүүлэх, цахилгаанжихгүй нэмэлт хамгаалах чадварын үзүүлэлтүүд нь 5 удаагийн угаалтын дараа анхны шинж чанараа хадгалж байх ёстой.
3. Химийн болон энгийн цэвэрлэгээний дараа ажлын хувцасны материалын хэмжээний өөрчлөлт урт ба өргөнөөрөө 3 хувиас хэтрэхгүй байна.

2. Өвлийн хувцасны зохион бүтээлт

2.1 Ерөнхий шаардлага

1. Хувцасны загвар ба хэмжээ нь өмсөх хүний биед эвтэйхэн, хөдөлгөөнд саад болохоргүй байна.
2. Хувцасны зохион бүтээлт нь түүнийг өмсөх үед ажил хөдөлмөр эрхлэхэд саад болохгүй байна.
3. Үйлдвэрлэлийн болон гадны нөлөөллөөс хамгаалах чадвар сайтай байна.
4. Өвлийн хувцас нь биеийн болон гарын чөлөөт хөдөлгөөнийг хангах зорилгоор ханцуйн урд хэсгийн оруулгыг энгэрийн хажуугийн босоо оруулгатай босоо нэг бүрдэл хэсэг байхаар хийнэ.
5. Зуны хувцас нь хөлс нэвтрүүлдэг байх.

2.2. Ажлын тусгай хувцасны өнгө

1. **Өвлийн хүрэм нь:** Үндсэн өнгө нь **Улаан хүрэн**,: халаасны даралтын өнгө нь **Хар саарал/К 817/** байх.

2. **Өвлийн өмд:** Үндсэн өнгө нь **Хар саарал /К 817/,** хажуу халаасны өнгө **Улаан хүрэн** байх.

Хүрэмний загвар, хийцэд дараах зохион бүтээлт, хийцүүдийг тусгасан байна.

- Цахилгаанаараа салхи орох, дулаан алдахаас сэргийлэх даралт /планктай/ дарсан байх.
- Дотор үндсэн дулаалга нь: Үндсэн өнгөнөөс салдаггүй, нэмэлт салдаг зөөлөн нэхий дулаалгатай.
- Нэмэлт нэхий дулаалга нь: Гадартайгаа цахилгаанаар холбогдсон байх.
- Захны дотор тал нь: Зөөлөн материалтай хүрэмний цахилгаан нь захны үзүүр хүртэл татагдддаг байх.
- Малгай нь: Захандаа бэхлэгдсэн байх. Захны ирмэгээр салдаг үстэй захтай байна.
- Ханцуйн үзүүрийн дотор талд салхи орохгүй загвартай байх.
- Бүсэлхийн хэсэгт салхи орохоос хамгаалж гүйдэг уяатай бүстэй.
- Энгэрийн дээд хэсэгтээ халаастай. Ташаандаа эзлэхүүнтэй ил халаастай
- Энгэр, ар нуруунд гэрэл ойдог тууз болон байгууллагын лого байршуулсан байна.

Өмдний загвар, хийцэд дараах зохион бүтээлтийн хийцүүдийг тусгасан байна

- Нуруугаар салхи орохоос хамгаалах комбинзон, бүсэлхийгээрээ сунаж агших чөлөөтэй өмсөх оруулгатай.
- Өвдөгний хэсэгт давхарлагатай.
- Арын суудлын хэсэгт давхарлагатайд ташааны оёдолд орсон халаастай
- Хоёр хажуу талдаа тагтай эзлэхүүнтэй ил халаастай.
- Салтааны хэсэгт нэмэлт оруулгатай. /Урагдаж ханзрахаас хамгаалсан хоёр давхар оёдолтой/
- U суулттай өмсөхөд эвтэйхэн суулт өндөр байх.
- Өвлийн дулаалгатай хүрэм, өмдний загвар, хийц, зохион бүтээлт нь зураг-1 –д үзүүлсний дагуу байна.

Зураг 1 : Өвлийн хувцасны загвар

3. Зуны хувцасны зохион бүтээлт

3.1. Ерөнхий шаардлага

1. Хувцасны загвар ба хэмжээ нь өмсөх хүний хөдөлгөөнд саад болохоргүй байна.
2. Хувцасны зохион бүтээлт нь түүнийг өмсөх үед биед эвтэйхэн, ажил хөдөлмөр эрхлэхэд саад болохгүй байна.
3. Үйлдвэрлэлийн болон гадны нөлөөллөөс хамгаалах чадвар сайтай байна.

3.2. Ажлын тусгай хувцасны өнгө

1. **Зуны хүрэм нь: Үндсэн өнгө нь Улаан хүрэн, нэмэлт оруулга нь: Хар саарал /К 817/.**
2. **Зуны өмд: Үндсэн өнгө нь Хар саарал /К 817/, хажуу халаасан дээр Улаан хүрэн өнгийн оруулга хийж өгөх.**

Хүрэмний загвар, хийцэд дараах зохион бүтээлтийн хийцүүдийг тусгасан байна

- Цээжний дээд хэсэг ханцуйн таллаж хосолгоо өнгө оруулсан.
- Эзлэхүүн бүхий тагтай ил халааснууд нь багтаамж сайтай, хийсэн зүйл нь сугарч унахааргүй байх.

Өмдний загвар, хийцэд дараах зохион бүтээлтийн хийцүүдийг тусгасан байна

- Өвдгөвч, суудлавч давхарлаж бүх оёдлыг давхар оёогоор оёсон, U суулттай байх.
- Хажуу халаасанд улаан өнгийн оруулга, гэрэл ойлгогч оруулж өгөх.
- Салтааны хэсэг нэмэлт оруулгатай. Урагдахаас хамгаалсан давхар оёдолтой байна.
- Зуны хүрэм, өмдний загвар, хийц, зохион бүтээлт нь зураг-2 -т үзүүлсний дагуу байна

Зураг 2: Зуны хувцасны зураг

4.Тосны хувцас

Тостой тоноглолт ажиллахад зориулагдсан тосноос хамгаалах материалаар хийгдсэн хөх, цэнхэр өнгөтэй комбинзон байх. Размер 2 XL болон түүнээс дээш байх.

5. Ажлын бээлий

5.1 Ерөнхий шаардлага:

Төрөл бүрийн ажлын байранд хүний гарыг механик үйлчлэл, цахилгаан хүчдэл, доргионоос хамгаалах. Сайн чанарын арьс болон цахилгаан гүйдлийн үйлчлэлээс хамгаалсан зориулалт бүхий материалтай байх.

5.2 Тусгай шаардлага:

- Бээлий болон түүний баглаа боодол дээр тэдгээрийн зориулалт, ашиглалтын зааврыг бичсэн байна.
- Бээлийг зориулалтаар нь ашиглахад гарын арьсанд сөрөг нөлөөлөл, цочрол үзүүлэхгүй байна.
- Бээлий нь хөнгөн, гар, хурууны хөдөлгөөнд саад дарамт учруулахгүйгээр хийгдсэн, эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлагад нийцсэн байна.
- Бээлийний эдэлгээ даах чадвар, зүсэлт тэсвэрлэх чадвар, давтан хэрэглэх боломж, хатгалт тэсвэрлэх чадвартай байна.

5.3 Өвлийн ажлын бээлий.

Гадна материал нь: Цэвэр зөөлөн арьс, **Дотор материал нь:** зөөлөн нэхий дотортой. MNS: 5622:2011 стандарт хангасан байх.

5.4 Шуурхай ажиллагааны ажилчдын ажлын бээлий:

Электрон тоног төхөөрөмжийн угсралт хяналт шалгалт, цахилгаан байгууламжид сэлгэн залгалт хийх ажилд өмсөхөд зориулагдсан. 13 гэйжийн нэхээстэй, пайлон болон карбон давхаргатай, статик цахилгаанжилтыг дамжуулдаггүй. Европын холбооны EN 388 болон EN 420:2003 стандартуудыг хангасан гэрчилгээтэй байна.

6 . Хантааз

1. Ажлын хантаазны зүүн энгэрт мөрний залгааснаас доош 10см орчимд компанийн логоны дээд ирмэг байхаар оёно.
2. Ажлын хантаазны баруун энгэрт мөрний залгааснаас доош 10см орчимд компанийн логоны 3-н фазын өнгийг уусгасан өнгөөр оруулсан байна. Нэг өнгөний өргөн нь 1 см, нийт 3-н өнгөний өргөн нь 3 см байна.
3. Ажлын хантаазны арын хэсэгт компанийн лого бүхий нэр /ББЭХС ТӨХК /-ийг товчилсон хэлбэрээр шар өнгөөр оёно.
4. Үсгийн өндөр нь **1.5** см, өргөн нь **1** см байх ба оёосны өргөн **3** мм шар өнгөтэй байна.

7. Гагнуурын хувцас

Галд тэсвэртэй. Европын холбооны EN ISO11611:2015 стандартын шаардлага хангасан ARC 2-р зэргийн дулааны хамгаалалттай, гагнуурчин өмсөхөд тохиромжтой, 99%-ийн хөвөн даавуу болон 1%-ийн карбон ширхэгтээр нэхэгдэн, галд тэсвэртэй өндөр технологиор боловсруулагдсан, угааж болдог, галд тэсвэртэй байх.

8.Тусгай заалт

Тендерт оролцогч нь санал болгож буй өвөл зуны ажлын хувцас болон ажлын бээлий тус бүрээс нэг нэгийг ББЭХС ТӨХК-д ирүүлэх. /Тендерт шалгараагүй тохиолдолд загвар хувцсыг буцаан хүргүүлнэ/

ХЯНАСАН:ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР		Ц.ТООРОЙХҮҮ
БОЛОВСРУУЛСАН:ХАБ ИНЖЕНЕР		Б.БУЯНХИШИГ-Г
		М. ЭНХЦЭЦЭГ